



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэлд тусгах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Германы Олон улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн “Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт” төслийн албан хэрэгцээнд ашиглаж байсан нийт 109,284,259,97 /нэг зуун есөн сая хоёр зуун наян дөрвөн мянга хоёр зуун тавин есөн төгрөг ерэн долоон мөнгө/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төв, Завхан аймгийн Политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төвийн дарга Ц.Батдорж, Завхан аймгийн Политехник коллежийн захирал Ц.Рэнцэнванжил нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1.Хөрөнгө хүлээлцэж, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Авсан арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажилдахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн
209 дугаар тогтоолын хавсралт



“Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн
боловсрол, сургалт” төслөөс шилжүүлэх автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Бүртгэлтэй үнэ /төгрөг/	Тоо ширхэг	Хүлээн авч, бүртгэх байгууллагын нэр
1	Ландкрузейр-105, 53-42 УБЛ, арал № JTECB09J103028242	2006/ 2006	35,463,480.00	1	Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээний төв
2	Ландкрузейр-76, 79-32 УНУ, арал № JTEEB71J307023226	2013/ 2014	73,820,779.97	1	Завхан аймгийн Политехник коллежи
	Нийт дүн		109,284,259,97 /нэг зуун есөн сая хоёр зуун наян дөрвөн мянга хоёр зуун тавин есөн төгрөг ерэн долоон мөнгө/	2	